

ХЯТАД, ЯПОНЫ ХУДАЛДАА, ЭДИЙН ЗАСГИЙН ХАМТЫН АЖИЛЛАГАА

*У.Загдцэсэм**

1972 онд Хятад, Япон хоёр улс нь дипломат харилцаагаа хэвийн болгосноос хойш олон салбарт бүтээлчээр хамтран ажиллаж байгаагийн нэг нь эдийн засгийн салбарын хамтын ажиллагаа юм.

Эдийн засаг худалдааны хамтын ажиллагаа нь Хятад, Японы харилцааны хөгжлийн чухал тал болсоор ирсэн. Хятад, Японы худалдааны хэмжээ 1972 онд 1 тэрбум 100 сая ам.доллар байсан бол 2006 онд 207 тэрбум 400 сая ам.долларт хүртэл өсч, 200 дахин нэмэгдсэн байна.

Хятад, Япон хоёр орон нь худалдааны салбарт хамтран ажиллаж Япон улс арван жил дараалан Хятадын худалдааны хамгийн том түнш байж, Хятад улс ч мөн адил Японы худалдааны 2-р том түнш, экспортын 2-р том зах зээл болсон.

Гэсэн хэдий ч сүүлийн жилүүдэд Хятад, Японы эдийн засгийн хамтын ажиллагаа нь буурах хандлагатай байгаа юм.

Хятадын Худалдааны Яамны Олон улсын худалдаа эдийн засгийн хамтын ажиллагааны судалгааны хүрээлэнгийн судалгаагаар “Өнгөрсөн 5 жилд Хятад, Японы худалдааны хэмжээ хоёр дахин нэмэгдсэн, 2006 онд хоёр орны худалдааны нийт хэмжээ 200 тэрбум ам доллараас давж, эдийн засаг худалдааны харилцаа жил ирэх тусам гүнзгийрч байгаа байгаа боловч сүүлийн жилүүдэд Хятад, Японы худалдааны ахиц төдийлөн их биш байгаа. Япон улстай хийсэн худалдааны хэмжээ нь Хятадын бүх гадаадтай хийсэн худалдаанд эзлэх хувийн жин ч буурсаар байна” гэжээ. Мөн “Сүүлийн жилүүдэд Хятад улс Европын холбоо, Америк, БНСУ-тай хийсэн худалдааны хэмжээ бүр 20 хувиас дээш нэмэгдсэн атал Япон улстай хийсэн худалдааны хэмжээ арван хэдхэн хувь л нэмэгдсэн. Үүнээс гадна Хятадын худалдааны хувийн жинд эзлэх Хятад, Японы худалдааны хэмжээ ч буурсаар байна” хэмээн тус тус дүгнэгджээ. Ямар шалтгаанаар Хятад, Японы худалдааны хэмжээ буурч байна вэ? гэсэн асуултанд хоёр зүйл шалтгаан буй хэмээн судлаачид үзэж байна. Үүнд: Нэгд, улс төрийн харилцааны талаас авч үзвэл, Японы Ерөнхий сайд асан Коизүми Жүничирогийн Ясүкүни сүмд мөргөл үйлдсэнтэй холбогдуулан Хятад, Японы улс төрийн харилцаа хурцдаж, дээд зиндааны айлчлал 5 жил тасалдсан. Улс төрийн талаас болж хоёр орны хоорондын дээд зиндааны айлчлал тасалдсан нь эдийн засаг худалдааны салбарын хамтын ажиллагаанд шууд сөргөөр нөлөөлсөн. Хоёрт, эдийн засгийн талаас авч үзвэл, сүүлийн жилүүдэд Япон “Хятад+1” гэдэг эдийн засаг худалдааны

* У.Загдцэсэм - ОУСХ-ийн эрдэм шинжилгээний ажилтан, магистр

арга барилыг хэрэгжүүлсэн. Энэ нь улс төрийн харилцаа тааруухан болохоор Азиас өөр нэгэн орон юм уу, Хятад улстай явуулж ирсэн эдийн засаг худалдааны харилцаагаа өөр орноор орлуулах, эсвэл Хятадтай байх эдийн засаг худалдааны хэмжээгээ багасгах шаардлагатай байсан.

Хятад, Японы эдийн засаг худалдааны хамтын ажиллагааны энэхүү бууралт нь Японы аж ахуйн нэгжүүдийн Хятадын зах зээлд ороход нөлөөлсөн бөгөөд ялангуяа, 2006 онд Японы аж ахуйн нэгжийн Хятад дахь хөрөнгө оруулалт тодорхой хэмжээгээр буурчээ.

Хятад, Японы эдийн засгийн салбар төдийгүй улс төрийн харилцаанд чухал хувь нэмэр оруулсан үйл явдлыг Хятадын Ерөнхий сайд Вэнь Жябаогийн урилгаар Японы Ерөнхий сайд асан Шинзо Абэгийн Хятад улсад 2006 оны 10 дугаар сарын 8-9-ны өдрүүдэд айлчилсан айлчлал гэж нэрлэж болох юм. Шинзо Абэ Ерөнхий сайд болмогцоо ялангуяа, Японы удаа дараагийн ерөнхий сайд нарын ерөнхий сайдын тушаалд оронгуутаа Америкт айлчлал хийдэг хуучин уламжлалыг эвдэж, хамгийн түрүүнд Хятадад “мөс хайлуулах” айлчлал хийж, Хятад болон Өмнөд Солонгос зэрэг эргэн тойрны орнуудтайгаа харилцаагаа сайжруулах чухал алхам хийсэн юм.

Хятад улсад айлчилсан Японы Ерөнхий сайд Ш.Абэгийн айлчлалыг сүүлийн таван жилийн хугацаанд болоогүй чухал ач холбогдолтой дээд хэмжээний уулзалт, энэ хоёр орны дипломат найрсаг харилцаанд маш чухал ач холбогдолтой айлчлал боллоо хэмээн олон улсын агентлагууд мэдээлж байв. Японы Ерөнхий сайд Шинзо Абэгийн айлчлалын үеэр Хятадын удирдагч Ху Жинтао хэлэхдээ “Таны Бээжинд хийж байгаа айлчлал нь БНХАУ болон Япон улсын хамтын ажиллагааг дахин шинээр эхлүүлэх чухал алхам болж байна. Энэхүү айлчлал хоёр орны хамтын ажиллагааг цаашид шинэ түвшинд гаргаж тавихад тус нэмэр үзүүлэх болно” гэж хэлжээ. Харин Хятадын Ерөнхий сайд Вэнь Жябао Японы Ерөнхий сайдыг хүлээн авах үедээ, Ерөнхий сайд байсан Жүничиро Коизүмигийн Ясүкүни сүмд хийсэн мөргөл нь хоёр орны хоорондох гадаад харилцаа, худалдаа эдийн засгийн бүхий л салбарт нөлөөлсөн гэдгийг дурдсан байна. Энэхүү айлчлал нь Хятад, Япон хоёр орны улс төр, эдийн засгийн салбарын харилцааг мухардмал байдлаас гаргаж, сэргээн тогтооход чухал хувь нэмрээ оруулсан айлчлал төдийгүй Хятад, Японы найрамдлын талаарх хоёр орны жирийн иргэдийн сэтгэл санааны суурийг дээшлүүлэхэд тустай алхам болов.

Үүний дараа Хятад улсын Ерөнхий сайд Вэнь Жябаогийн 2007 оны 4 дүгээр сарын 11-нд Японд хийсэн айлчлал нь Хятад, Японы дээд хэмжээний айлчлал 5 жил тасалдсаны эцэст Хятадын удирдах хүн Японд анх удаа айлчилсан айлчлал болсон бөгөөд Хятад, Японы харилцаа эдийн засгийн хамтын ажиллагаанд бага бус хувь нэмэр оруулсан, хоёр талын харилцааг зөөлрүүлсэн айлчлал болсон гэдгийг дурдууштай.

Хятад улсын Ерөнхий сайд Вэнь Жябаогийн Япон улсад хийсэн айлчлалын үеэр Хятад, Японы эдийн засгийн хамтын ажиллагааны механизм тогтоохтой холбогдуулан хоёр орны ерөнхий сайд нар хэлэлцээ хийсэн бөгөөд энэхүү хэлэлцээр нь эдийн засгийн талаар хоёр орны стратегийн харилцан хөнгөлөлт үзүүлэх харилцаа тогтоох чухал арга хэмжээ болов. Мөн энэ удаагийн айлчлал Хятадын зах зээлд үйл ажиллагаагаа явуулж буй Японы аж ахуйн нэгжид нэн аятай уур амьсгал бий болгосон юм.

Энэхүү 2007 он нь Хятад, Японы хоорондын харилцаа хэвийн болсон 35 жилийн ой тохиож буйгаараа онцлог жил болж өнгөрч байна. Хоёр орны удирдагчид энэ оныг “Хятад, Японы соёл, биеийн тамирийн харилцааны жил” болгон тэмдэглэж, хоёр талын ойн үйл ажиллагааг зохион байгуулах комисс байгуулагдан, хоёр орны соёл, биеийн тамирийн төрөл бүрийн үйл ажиллагааг зохиож, хоёр ард түмний солилцоог цаашид өргөтгөн, ард түмэн хоорондын харилцан ойлголцлыг нэмэгдүүлэхэд чармайн ажилласан нь тухайн хоёр орны харилцаа хамтын ажиллагаанд хоёр талын хүчин чармайлт тавьсаны үр дүн юм.

Хятад, Японы эдийн засгийн хамтын ажиллагааны хүрээнд багтах өөр нэг чухал хэлбэр бол Хятадад үзүүлж ирсэн Япон улсын засгийн газрын хөгжлийн тусламж юм.

Японы засгийн газрын хөгжлийн тусламж /ODA/ болон буцалтгүй тусламжийн бүх төрөл зүйл, чиглэлээр үзүүлж буй тусламж дэмжлэгийн хэмжээгээр Азийн орнуудаас Хятад улс эхний байранд ордог.

1979-1983 онд хэрэгжүүлсэн анхны удаагийн иенийн зээллэгээр Япон Хятадад 330 тэрбум иен, 1984-1989 онд хэрэгжүүлсэн хоёр дахь удаагийн иенийн зээллэгээр дэд бүтэц, төмөр зам, усан боомт, метро барихад зориулж нийт 470 тэрбум иен, 1990-1995 онд нийт 42 төслийг хэрэгжүүлэхэд зориулж 810 тэрбум иенийн зээллэгийг олгосон бөгөөд энэхүү зээллэгийг жилд 1,5 хувийн хүүтэй 30 жилийн хугацаатай зээлдүүлэх тааламжтай нөхцөл олгож байжээ. Хятадын эдийн засгийн өсөлтийн хурдац ч Японы энэхүү зээл тусламжтай ихээхэн холбоотой. Япон улс Хятадад жил бүр нэг тэрбум ам.долларын хөгжлийн тусламж үзүүлж байна.

Хэдийгээр Хятад Японы харилцаа хамтын ажиллагаанд ээдрээтэй асуудлууд оршсоор байгаа ч ялангуяа, хоёр орны Ерөнхий сайд нарын харилцан айлчлал амжилттай болж өнгөрсөн нь хоёр орны улс төрийн харилцаанд үүссэн хурцадмал байдлыг намжааж, улмаар эдийн засгийн харилцааг зогсонги байдлаас идэвхитэй шинэ шатанд гаргахад эерэгээр нөлөөлсөн явдал юм. Ийнхүү Хятад, Японы эдийн засгийн хамтын ажиллагаанд цаашид өөдрөг, харилцаа хамтын ажиллагааны дүр зураг ажиглагдаж байна. Хятад, Японы эдийн засгийн хамтын ажиллагаа нь

амжилт олох нь тухайн хоёр орны эдийн засгийн хамтын ажиллагаанд нөлөөлөөд зогсохгүй цаашлаад Зүүн Азийн орнуудын эдийн засгийн хамтын ажиллагаанд ч нөлөөлөх болно.

Ашигласан материал

1. <http://mn1.chinabroadcast.cn>
2. NIRA Policy Research January 2005. vol18, №1
3. <http://www.adb.org>
4. <http://www.china-embassy.org/eng/gyzg/t58834.html>
5. <http://www.sonin.mn>
6. Конрад Зайц “Хятад: Дэлхийн их гүрэн эргэн ирж байна” УБ., 2006.
7. ERINA REPORT Vol.55